



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,

Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,

Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2025.02.25 № 310
танай _____-ы № _____-т

「ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН」
ХЭЛТСИЙН ДАРГА Б.ТӨРХҮҮ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу танай байгууллагын 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэхэд 18,303.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,372.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 16,930.4 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ж.ГАНБААТАР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23

Дугаар 29-А/2360453

Чингис хот

ХЭА-2026/135/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нэр бүхий 20 ажилтанд 16,930,390.00 /Арван зургаан сая есөн зуун гучин мянга гурван зуун ерэн/ төгрөгийн илүү цагийн хөлсийг архивын улсын үзлэгт бэлдэх нэрээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4-т "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль, тогтоомжид заагдаагүй ажил үүрэгт илүү цагийн хөлсийг олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Төрхүү-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Г.ЭНХ-АМГАЛАН